

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
“МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ” ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН
ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ
ТӨСӨЛД ХИЙСЭН МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ
ДҮН ШИНЖИЛГЭЭ

2024 ОН

Хэлэлцээр соёрхон батлах тухай

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах” тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр батлах төсөлд хийсэн Монгол Улсад үзүүлэх үр нөлөө, үр дагаврын талаарх дүн шинжилгээ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлын Дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурал соёрхон батлах хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах бол уг олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний эцэслэн тохиролцсон, эсхүл үзэглэсэн төсөл, эсхүл баталсан буюу жинхэлсэн эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, тэдгээрийн орчуулга, олон улсын гэрээнд нэгдэн орсноор Монгол Улсад үзүүлэх үр нөлөө, үр дагаврын талаарх дүн шинжилгээний хамт тухайн олон улсын гэрээнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлнэ” гэж, мөн “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг боловсруулахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу дараах нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэв.

ХОЁР. ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ЗОРИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2.1-т “Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.” гэж, мөн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн

2.1.4-т “Дулааны гуравдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 300 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.6-д “Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дулааны гуравдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтын хүрээнд 4.2.34-т “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.”, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 3.7.17-д “Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудыг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлын цар хүрээг нэмэгдүүлэх, найдвартай тогтвортой үйл ажиллагааг хангах, нөөц чадлыг зохистой хэмжээнд хүргэх шаардлага үүссэн.

Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд өвлийн их ачаалалд системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр өвлийг давж байна. Тодруулбал, 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр системийн оргил ачаалал 1636 МВт хүрч, 71 МВт-ийг хязгаарласан бөгөөд цаашид эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийг эрчим хүчээр хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байна. Мөн Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 2418 Гкал/ц, нийт холбогдсон хэрэглэгчдийн дулааны тооцоот ачаалал 3373,7 Гкал/ц-т хүрч 955,7 Гкал/ц-ийн дулааны эрчим хүчний дутагдалтай байна.

Хэлэлцээр батлагдсанаар эхний ээлжинд зураг төсөл боловсруулах ажлыг Оросын Холбооны Улсын талаас санал болгож, эрх олгосон компаниар гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалт бий болно. Ингэснээр Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэтгэлийн төслийн нийт төсөвт өртөг барилга угсралтын хугацааг

нарийвчлан тодорхойлж харилцан зөвшилцсөнөөр цаашид барилга угсралтын ажил, Оросын Холбооны Улсаас экспортын зээл авах асуудлаар хэлцэл хийх нөхцөл боломж бүрдэнэ.

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт-ын (1х50 МВт) блок станцаар өргөтгөн, дунд даралтын хэсгийн 48 МВт-ын (4х12 МВт) блок станцыг буулгаж суурин дээр нь 250 МВт-ын (2х125 МВт) блок станц шинээр барьсанаар Хан-уул дүүрэг, Баянзүрх дүүргийн хэрэглэгчдийг дулаанаар, Төвийн эрчим хүчний системийн хэрэглэгчдийг цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах нөхцөл бүрдэж байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах” тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах төслийн дагаж мөрдөх үйлчлэх хугацааг Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг хийж дууссаны дараа дуусгавар болгохоор тусгасан бөгөөд талууд хэлэлцээрийг цуцлах өдрийг дипломат шугамаар нот бичиг солилцох замаар тогтоохоор тусгагдсан болно.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 1 зүйлтэй байна.

Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулахтай холбоотой оролцогч талуудыг тодорхойлно.

ДӨРӨВ. ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА БҮЛГИЙН ТАЛААР

Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах төслийн захиалагчаар “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани, гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг

томилох асуудал нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 2-р зүйлд зааснаар зохицуулагдана.

Монгол улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулснаар төслийн нийт төсөвт өртөг, барилга угсралтын ажлын хугацааг нарийвчлан тодорхойлох тул “Хэлэлцээр батлах тухай” хууль батлагдсанаар эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх асуудал үүсэхгүй болно.

ТАВ. МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд эрх тэгш, харилцан ашигтай, урт хугацааны стратегийн хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан хоёр Улсын эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор энэхүү хэлэлцээрийг байгуулсан.

Хэлэлцээр соёрхон батлагдсанаар Монгол улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулж, төслийн нийт төсөвт өртөг, барилга угсралтын ажлын хугацааг нарийвчлан тодорхойлох бөгөөд төвийн бүсийг цахилгаан эрчим хүчээр, Улаанбаатар хотыг дулааны эрчим хүчээр хангах шинэ эх үүсвэр бий болох нөхцөл бүрдэнэ.

Мөн зураг төслийн үр дүнг талууд харилцан зөвшилцсөнөөр Оросын талаас хөнгөлөлттэй зээл авах асуудлаар хэлцэл хийх үндсэн баримт бичгийг бүрдүүлнэ.

ЗУРГАА. ХУУЛЬД ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ӨРСӨЛДӨӨНИЙГ ХЯЗГААРЛАСАН, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНД СААД ХОРИГ УЧРУУЛСАН, АЛИВАА ХҮНД СУРТАЛ, АВЛИГА ГАРАХ НӨХЦӨЛ БОЛОМЖ БҮРДҮҮЛСЭН БАЙЖ БОЛЗОШГҮЙ ЗОХИЦУУЛАЛТ АГУУЛЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААР

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах” тухай Монгол Улсын Засгийн Газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах хуульд төрийн болон төрийн бус байгууллага, компани, хувь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, бусад саад хориг учруулсан, хүнд суртал,

авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулагдаагүй болно.

ДОЛОО. ТУХАЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХУУЛЬ, ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БАЙГАА ЭСЭХ ТАЛААР

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгуу “Олон улсын гэрээний тухай” хууль.

НАЙМ. ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ, ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООНЫ ТАЛААР:

Хуулийг хэрэгжүүлэхэд нэмэлт хүний нөөц, техник, эдийн засгийн хэрэгцээ шинээр үүсэхгүй болно.

Хэлэлцүүлгийн мэдээлэл:

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 29 дүгээр тэмдэглэлд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтож Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо дэмжсэн тохиолдолд уг хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийг ажлын журмаар гаргахаар тогтов.

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, Гадаад бодлогын байнгын хорооны санал дүгнэлтээр зөвшилцөн дэмжсэн.

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтээр зөвшилцөн дэмжсэн.

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын

өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтээр зөвшилцөн дэмжигдсэн.

ХУУЛЬ САНААЛАГЧ